



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2015 оны 7 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар  
хот

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг  
шинэчлэн батлах тухай

1. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 20.3-т заасныг үндэслэн Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- |              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|--------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дарга        | -Аж үйлдвэрийн сайд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| Орлогч дарга | -Хөдөлмөрийн дэд сайд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Гишүүд:      | -Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч;<br>-Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газрын дарга;<br>-Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;<br>-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Инноваци, өндөр технологийн газрын дарга;<br>-Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын дарга;<br>-Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлого зохицуулалтын газрын дарга;<br>-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;<br>-Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;<br>-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын төлөөлөл (тохиролцсоноор);<br>-Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөлийн төлөөлөл (тохиролцсоноор); |

-Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны төлөөлөл (тохиролцсоноор);

-Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил нэгдсэн холбооны төлөөлөл (тохиролцсоноор);


-Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны төлөөлөл (тохиролцсоноор).

Нарийн бичгийн  
дарга

-Аж үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

2. Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн санал, зөвлөмж гарган хэрэгжүүлж ажиллахыг Аж үйлдвэрийн сайд, Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөлийн дарга Д.Эрдэнэбатад үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Үндэсний зөвлөл байгуулах тухай” Ерөнхий сайдын 2009 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 49 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ